

БАТЛАВ:

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ-ИЙН

ЗАХИРАЛ

Х.ПҮРЭВЖАРГАЛ



**А0102 ДУГААРТАЙ УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМД БАЙРЛАХ АЙРАГ ТӨЛБӨР  
АВАХ ЦЭГИЙН АВТО ЗАМ ЗАСВАР, ПҮҮ ЗАСВАРЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2023 оны 04 дугаар сарын 03-ны өдөр

№

Улаанбаатар хот

1	Боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"><li>- Улсын төсөв, авто замын сангийн хөрөнгө оруулалтаар улсын чанартай авто замын урсгал засвар, арчлалтын ажлын 2023 оны төлөвлөгөөнд тусган <b>Айраг</b> төлбөр авах цэгийн авто пүүг засварлах, зам талбайн хучилт хийх</li><li>- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны "Ажлын жагсаалт батлах тухай" А/34 дугаар тушаалын хавсралтаар баталсан Олон улс улсын чанартай авто ашигласны төлбөр авах цэг нүүлгэн шилжүүлэх, засварлах, зураг төсөл боловсруулах, зам хариуцагч компанид тоног төхөөрөмж худалдан авах ажлын жагсаалтыг үндэслэл болгов.</li></ul>
2	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	<ul style="list-style-type: none"><li>- Дорноговь Айраг төлбөр авах цэг</li></ul>
3	Зориулалт, хүчин чадал	<ul style="list-style-type: none"><li>-Төлбөр авах цэгийн барилга байгууламжийн зураг төслийг Монгол Улсын стандарт "Авто замын төлбөр хураах цэг" MNS6592:2016 стандартыг баримтлан гүйцэтгэнэ.</li><li>- Зураг төсөлд зам талбай, авто пүү суурилуулах, цахилгаан хангамж, зэргийг захиалагчтай зөвшилцөн тусгана.</li><li>- Тээврийн хэрэгслийн тэнхлэгийн болон бүх жинг тодорхойлох мэдээлэх электрон лед самбарын хамт 1 ширхэгийг <b>ОМЛЕ</b> "Олон улсын зөвлөмж"-ийн дагуу хийж гүйцэтгэнэ</li><li>- Одоо байгаа авто пүүг сугалан суурийн хийцлэл, ус зайлуулах суваг, цахилгааны монтажыг дахин хийн түвшинг замын түвшинтэй тэнцүүлэн суурилуулна</li><li>- Суурилуулагдсан байгаа авто пүүний зам талбайг өргөсгөх, авто пүү рүү орох гарах гарцын өргөн нь том оврын тээврийн хэрэгсэл нэвтрэхэд огцом эргэлт үүсгэхгүй байх, авто замын хөвөө нь 1,5 метрээс багагүй байна</li><li>- Авто пүүний замын урт нь 21+21 метр, өргөн нь 3,5 метр, зузаан 0,20 метрээс багагүй хэмжээтэй бетон хучилттай /М300 маркаас дээш/ замын 2 талаар замын хашлаган хийцлэл бүхий тууш зам байна</li><li>- Тухайн орчны цаг агаарт тохируулан арматур, бетон заадас, арчилгааг стандартын дагуу хийж гүйцэтгэнэ</li><li>- Авто пүүний хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх, ус зайлуулах хоолой бүхий сувагчлал хийнэ</li></ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Авто зам дээр тээврийн хэрэгслийн хурд сааруулагчийг “Хурд сааруулагч Техникийн ерөнхий шаардлага, хэрэглэх дүрэм” MNS5968:2003 стандартын дагуу байгуулна</li> <li>- Төлбөр авах цэгийн барилга байгууламжийн авто пүүний хүчин чадлыг Монгол Улсын стандарт “Авто замын төлбөр хураах цэг” MNS 6592:2016 стандартыг баримтлан төсөллөх ба Авто замын өргөтгөл, зам талбайн зураг, цахилгаан шугам сүлжээний зураг төсөлд үндэслэж зураг төслийг боловсруулах</li> </ul>
4	Одоогийн байдал	- Улаанбаатар- Говь-Сүмбэр чиглэлд 1 талын авто пүүтэй. Орц гарц нарийн, авто пүү замын түвшин зөрүүтэй суурилуулагдсан.
5	Төсөл гүйцэтгэх хугацаа	- Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно
6	Төслийн захиалагч	- “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ
7	Төслийн гүйцэтгэгч	Хатуу хучилттай зам барих, зам засвар үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй байгууллага нь тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах өөрийн техник хэрэгсэлтэй байх/ Төв замын зураг төсөл боловсруулах, барилга байгууламж бусад инженер хангамжийн зураг төсөл боловсруулах ажлын тусгай зөвшөөрөлтэй, цахилгаан шугам сүлжээний зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй, Авто пүү суурилуулах тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудтай хамтран оролцоно.
8	Төсөл боловсруулах үе шат	<ul style="list-style-type: none"> <li>- Техникийн төсөл, загвар зураг /эскиз/ боловсруулж Захиалагчтай зөвшилцөнө.</li> <li>- Ажлын зураг төслийн иж бүрдэл, төсөвт өртгийг боловсруулж захиалагчаар батлуулах,</li> <li>- Авто пүүний зам талбайн ажил эхлүүлэх зөвшөөрлийг захиалагчаас авах,</li> <li>- Төлбөр хураах цэгийн авто пүүг засварлах, зам талбайн өргөсгөлийг хийх</li> <li>- Тоног төхөөрөмж, цахилгаан, барилга байгууламж туршилт тохируулга хийх</li> <li>- Захиалагчид хүлээлгэн өгөх</li> </ul>
9	Архитектур орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	- Орчны архитектур орон зайн төлөвлөлттэй уялдуулан зам талбайг төлөвлөх
10	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг орчны зам талбай, барилга байгууламжтай уялдуулан шийдвэрлэх</li> <li>- Төвлөрсөн цахилгаан хангамжид холбох системд холбох</li> </ul>
11	Төсөлд ашиглах материал	<p><u>Монгол улсын ХУУЛИУД:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Авто замын тухай хууль</li> <li>- Газрын тухай хууль</li> <li>- Барилгын тухай хууль</li> </ul> <p><u>Норм. Норматив</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Авто замын төлбөр хураах цэг. Ерөнхий шаардлага MNS 6592-2016</li> <li>- Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 256 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм”</li> <li>- Авто замын барилгын ажлын төсвийн жишиг норм ЗЗБНБД 81-25-2007</li> <li>- Авто зогсоол БНБД 21-05-10 Геодезийн ажил БНБД 3 01 03-88</li> <li>- Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм БНБД 81-94-12</li> <li>- Цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламжийн дүрэм БД 81-109-14</li> <li>- “Цахилгаан техникийн ажил” БНБД 3.05.06-90</li> <li>- Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4596:2014 Замын тэмдэглэл. Техникийн шаардлага MNS 4795:2014</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад ашиглагдах норм ба дүрмүүд</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм</li> <li>- Хурд сааруулагч Техникийн ерөнхий шаардлага, хэрэглэх дүрэм MNS 5968:2003</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм</li> </ul>
12	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан стандартын тэмдэг тэмдэглэл, тоноглол, гэрэлтүүлгээр бүрэн хангагдсан байна.</li> <li>- Төлбөр авах цэгийн авто пүүний ус зайлуулах суваг, хоолой нь холбогдох норм, төлөвлөлтөд мөрдөгдөх шаардлагыг хангасан байна.</li> <li>- Электрон суурин авто пүүг шалган тохируулсан байна.</li> </ul>
13	Зураг төслийн иж бүрдэл	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох техникийн нөхцөл</li> <li>- Авто зам талбай төлбөр хураах цэгийн арал болон байрны инженерийн нарийвчилсан зураг төсөл</li> <li>- Цахилгаан шугам сүлжээ ажлын зураг төсөл</li> <li>- Зургийн тайлбар бичиг</li> <li>- Техникийн шаардлага</li> <li>- Ажлын нэр төрөл, тоо хэмжээ</li> <li>- Зам талбай барилгын ажлын төсөв</li> <li>- Инженерийн шугам сүлжээний зураг төсөл</li> <li>- Ил далд ажлын акт</li> </ul>
14	Зураг төслийг хүлээж авах	Төлбөр авах цэгийн авто пүүний зам талбайн өргөтгөл, цахилгаан хангамжийн холболтын шугам сүлжээ, монтаж, хурд сааруулагч Зураг төслийн иж бүрдэл, төсөв, холбогдох бичиг баримтыг эх хувь 1 ш, хуулбар хувь 3 ш /хуулбар хувийг өнгөтөөр хувилах/, цахим хэлбэрээр /PDF/ захиалагчид хүлээлгэн өгнө.

ХЯНАСАН:  
ТӨЛБӨР АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЭНХБААТАР

АВТО ЗАМЫН АШИГЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Н. БААТАРДЭМБЭРЭЛ

АЖЛЫН ДААЛГАВРЫГ БОЛОВСРУУЛСАН:  
ТАУАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН



Л.ГАНЦЭЦЭГ

ТАУАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН



М.ӨСӨХБАЯР